



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/346

Ховд

Багц болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3. дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 109 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр Ховд аймагт Барилга, хот байгуулалтын яамнаас эрх шилжин ирсэн “Сумын тохижилт (Ховд, Алтай, Мөст, Эрдэнэбүрэн сум)” 600,000,000 төгрөг (зургаан зуун сая)-ийн өртөг бүхий БХБЯ/202212078 дугаартай ажлын тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зарлахдаа газар зүйн байрлалыг харгалзан дараах багц болгосугай. Үүнд:

- Сумын тохижилт (Ховд, Алтай сум) 1 дүгээр багц - 200,000,000
- Сумын тохижилт (Ховд, Мөст сум) 2 дугаар багц - 200,000,000
- Сумын тохижилт (Ховд, Эрдэнэбүрэн сум) 3 дугаар багц - 200,000,000

2. 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлагдсан төсөвт өртөгт нь багтаан барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хариуцан ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1348